

**АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 06 ДУГЭЭР САРЫН 26-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГСӨН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2023.07.24

Чойр

№	Үүрэг даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	Баяр наадам зохион байгуулахтай холбоотойгоор бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн дотор	Баяр наадам зохион байгуулахтай холбоотойгоор бүх нийтийн цэвэрлэгээг 6 дугаар сарын 25-аас 7 дугаар сарын 05-ны өдөр хүртэл угталтын хаалгаас алсын худаг хүртэл авто зам дагуу цэвэрлэгээ хийж, 1 тонн хог хаягдал, баяр наадмын өдрүүдэд наадмын талбайг цэвэрлэж 12 тонн хог хаягдыг цуглуулж, төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн.	100
2	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулах сургалтад албан хаагчдаа бүрэн хамруулах	2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр	“Төрийн албаны шинэтгэл, хандлага, зан үйлийн өөрчлөлт” сэдэвт сургалт нь 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Тус сургалтад 17 төрийн байгууллагын 130 албан хаагч хамрагдсан.	100
3	Баяр наадмын амралтын өдрүүдээр албан хаагчдаа аялал зугаалгаар явахдаа үер усны аюулаас сэрэмжлүүлж, аюулгүй байдлаа хангахыг анхааруулах	2023 оны 07 дугаар сарын 17-ны өдөр хүртэл	Онцгой байдлын газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “Үндэсний их баяр наадмын амралтын өдрийг тохиолдуулан “Хэрлэн гол”, “Хаялага нуур”-ын эрэг дагуу усны болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнт эргүүлийг томилон ажиллуулах ажлын удирдамж”-ийг батлан ажиллаж байна. Удирдамжийн дагуу 07 дугаар сарын 06-аас 16-ны өдрүүдэд аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл, Онцгой байдлын газар, Сүмбэр сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Улаанзагалмайн дунд шатны хороо, Цагдаагийн хэлтэстэй хамтран завьт эргүүлийг тогтмол зохион байгуулан, 842 иргэдэд /том хүн-536, хүүхэд-306/, 1501 ширхэг ухуулга сурталчилгаа, гарын авлага тарааж, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.	100
4	Баяр наадмын амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн үүргийг хуваарийн дагуу чанартай гүйцэтгэх	2023 оны 07 дугаар сарын 17-ны өдөр хүртэл	Аймгийн Засаг даргын 2023 оны А/209 дүгээр захирамжаар 07 дугаар сарын 10-аас 14-ний өдрүүдэд хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулсан. Хуваарийн дагуу 20 албан хаагч хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэсэн. 2023 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд усархаг аадар бороо орсны улмаас Сүмбэр суманд үерийн нөхцөл байдал бий болж төвийн айл өрх болон Сүмбэр сумын 5 дугаар багт айл өрхүүд усанд автсан, Баянтал, Сүмбэр сумын нутаг дэвсгэрт авто зам, төмөр зам хаагдаж, усанд боогдсон. Аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтэс, сумын Засаг даргын Тамгын газар, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ газар болон бусад холбогдох байгууллагуудаас гамшгаас хамгаалах, хор хохирлыг бууруулах чиглэлээр шуурхай арга хэмжээг зохион байгуулан ажилласан.	100

5	Багуудын иргэдийн нийтийн хуралд байгууллагууд албан хаагчдаа оролцуулах, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хийгдэх төсөл хөтөлбөр арга хэмжээнд санал өгүүлэх	2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хүртэл	Сүмбэр сумын багуудын иргэдийн нийтийн хуралд 17 байгууллагын 85 албан хаагч хамрагдаж, Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний саналыг эрэмбэлэхэд оролцсон. Баянтал сумын 1, 2 дугаар багийн иргэдийн нийтийн хуралд 76 иргэн оролцож, Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх 46 хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг эрэмбэлсэн. Шивээговь сумын 1, 2 дугаар багийн иргэдийн нийтийн хуралд “Алсын хараа 2050” Монгол улсын урт онд хийгдэх төсөл хөтөлбөр арга хэмжээнд санал өгүүлэх хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, суманд 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын саналыг эрэмбэлэх, мөн 1, 2 дугаар багуудын хил заагийн эргэлтийн цэгүүдийг тогтоох зэрэг асуудлуудыг хэлэлцсэн.	100
6	СӨХ-ны үйл ажиллагааг эрчимжүүлэхэд анхаарах, шаардлагатай арга авч хэрэгжүүлэх	2023 оны 07 дугаар сарын 17-ны дотор	Шивээ-Овоо ХК-ийн харьяа “Нарлаг Шивээ” СӨХ-ийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд чиг үүрэг, хуваарийн дагуу цэвэрлэгээ үйлчилгээ хийгдэж байна. 3, 6, 7, 8 дугаар байрнуудын СӨХ-ны үйл ажиллагаа зогсонги байдалтай байгаа бөгөөд тус байрнуудын сууц өмчлөгчдийн холбоог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэхээр ажиллаж байна. Сүмбэр сумын ЗДТГ азраас үүргийн биелэлт ирүүлээгүй.	30
Дундаж				88.3